



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2022.10.20 № 41

Г Махны экспортын тухай Г

Хөдөө аж ахуйн салбар нь 2021 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 12.8 хувийг эзэлсэн бөгөөд энэхүү үзүүлэлтээрээ уул уурхайн олборлолт болон үйлчилгээний салбарын дараа орж байгаа юм. Хөдөө аж ахуйн салбар дотор Мал аж ахуйн эзлэх хувь 80-аас дээш байгаа нь энэ салбар эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэж байгааг харуулж байна.

2016-2020 оны байдлаар улсын хэмжээнд 333.7 - 624.9 мян.тн мах бэлтгэсэн бөгөөд үүнээс 9.3 – 68.8 мянган тонныг нь экспортолсон байна. Гаалийн ерөнхий газраас гаргасан мэдээллээс харахад, 2018 онд хамгийн их буюу 68.8 мян.тн мах, махан бүтээгдэхүүн экспортолж, 400 тэрбум төгрөгийн худалдаа хийсэн байдаг. Түүнээс хойш жил ирэх тусам экспортын хэмжээ буурсаар байна.

Монгол Улс махны үйлдвэрлэл, түүний дотор адуун сүргийнхээ тоогоор дэлхийд 4, ямаан сүргээрээ 9, хонин сүргээрээ 10, тэмээн сүргээрээ 11, үхэр сүргээрээ 53 дугаар байранд тус тус жагсаж байна. 2020 онд дэлхий даяар 23.1 тэрбум ам.долларын үнэ бүхий үхрийн мах, 7.42 тэрбум ам.долларын үнэ бүхий хонь, ямааны мах, 397 сая ам.долларын үнэ бүхий адууны мах, нийт 30.9 тэрбум ам.долларын борлуулагдсан байдаг. Жилд 30 тэрбум орчим ам.доллар эргэлддэг энэ зах зээл дээр Монгол Улсын нийлүүлэлт маш хангалтгүй байна. Тухайлбал, 2021 онд 18.7 сая ам.долларын үнэ бүхий 8 642 тн мал, мах нийлүүлсэн бөгөөд энэ нь олон улсын зах зээл дэх энэ төрлийн бүтээгдэхүүний нийт худалдааны дөнгөж 0.06 хувийг эзэлж байгаа юм. Харин 2022 он гарсаар ердөө 1.0 мянган тн түүхий мах экспортлоод байна.

2021 оны байдлаар Монгол Улсад 188.6 мянган малчин өрх бүртгэгдсэн бөгөөд эдгээр өрхийн 5 хувь нь мянгаас дээш тооны малтай бол 56.3 хувь нь 200-аас доош тооны малтай, дөнгөж амьжиргаагаа залгуулах төдий орлого олж байна.

Иймд Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1-т заасныг тус тус үндэслэн, 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" УИХ-ын 24 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Монгол Улс жилд дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаад хичнээн хэмжээний мал, мах, махан бүтээгдэхүүн экспортлох боломжит нөөцтэй талаар;

2. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3.-т "Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ." хэмээн заасан байдаг. Тус заалтын хүрээнд мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар өнгөрсөн хугацаанд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлын талаар;


3. Тогтоолын 3.3.12.-т "Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ." гэж заасан. Энэ хүрээнд мах, махан бүтээгдэхүүн импортлогч орнуудтай хатуу гэрээ хэлцэл хийх, тээвэрлэлт, логистикийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр авч хэрэгжүүлж буй болон төлөвлөж буй арга хэмжээний талаар

4. globalproductprices.com сайтад мэдээлснээр, 2022 онд үхрийн мах олон улсын зах зээл дээр 61.6-3.74 ам.долларын үнэтэй худалдаалагдаж байна. Гэтэл хамгийн эрүүл, органик тэжээлтэй монгол үхрийн мах олон улсын зах зээл дээр хамгийн бага буюу 3.01-2.5 ам.доллараар худалдаалагдаж ирсэн. Иймд Засгийн газар мах, махан бүтээгдэхүүний үнийг барих асуудлыг зогсоох, цаашилбал экспортод гаргах мал, махны үнийг өсгөх чиглэлээр ямар арга хэмжээ авахаар төлөвлөж байгаа талаар;

5. Нийт мах, махан бүтээгдэхүүний экспортын 80 орчим хувийг адууны мах дангаараа эзэлдэг. Цаашид олон улсын зах зээл дээр илүү эрэлттэй бөгөөд үнэ хүрдэг үхэр, хонь, ямааны махны экспортыг нэмэгдүүлж чадвал экспортын орлого, үр өгөөжийг нэмэгдүүлэхээс гадна сүргийн бүтцийн зохист харьцааг хадгалж, бэлчээрийн даацад эерэгээр нөлөөлөх боломжтой. Засгийн газар энэ чиглэлээр ямар бодлого баримталж байгаа талаар тус тус дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэн ирүүлнэ үү.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Н.ГАНИБАЛ

2022000098